

нийг тодруулахад сонирхсон улс орон бүрийн эрдэмтдийн хамтын хүчин чармайлт чухал. Ийм утгаар Халхын голын дайны ил тод байдал гэж хэлж болохуйц тийм эрдэм шинжилгээний хурал боллоо гэж хэлж болно. Үнэхээр ч гурван орны эрдэмтэд нэгэн ширээг тойрон суугаад чөлөөтэй санал бодлоо хэлэлцэх явдлыг төсөөлөн бодоход бэрх байсан цаг саяхан. Түүхэн үнэний эрэл үргэлжилсээр... Улаанбаатарт болсон эрдэм шинжилгээний бага хурал энэхүү эрлийн замд нэгэн өртөө болсон нь дамжиггүй.

Ц. БАТБАЯР
1989—VIII—19

НОМЫН ШҮҮМЖ

**АМЕРИКИЙН ЭРДЭМТЭН ЗҮҮН-ХОЙД АЗИ
ДАХЬ АНУ-ЫН БОДЛОГЫН ТУХАЙ**

Scalapino Robert. The United States and Northeast Asia. Prepared as Background for the Visit of President George Bush to Asia. February 1989. The Asia Society. Media Briefing. N. Y., 1989—III + 50 p,

Скалапино Роберт. АНУ ба Зүүн-Хойд Ази. Америкийн ерөнхийлөгч Жорж Бушийн Азид хийх айлчлалд зориулсан тойм. 1989 оны 2-р сар. Эйша Сосайети. Мэдээлэл. Нью-Йорк, 1989. — Ш + 50 х.

Энэ бүтээлийг олон улсын бодлогын чухал бүс нутгийн нэг Зүүн хойд Ази дахь АНУ-ын гадаад улс төрийн бодлогын урьдчилсан байдлын тухай азийн асуудлаархи америкийн шинжлэн судлаач, Калифорнийн Их сургуулийн Зүүн азийн асуудал судалдаг институтын захирал, профессор Роберт Скалапино туурвисан юм. Профессор Р. Скалапино бол Ази-Номхон далайн бүсийн тулгамдсан чухал асуудлаархи америк-монголын эрдэмтдийн уулзалтыг санаачлагчдын нэг юм.

Эрдэм шинжилгээний бүтээлийн дотор АНУ-аас Япон, БНХАУ, Өмнөд Солонгостой харилцаж байгаа харилцааны асуудал гүн гүнзгий утга агуулгатай юм. Үүнд: Зүүн-хойд Азийн олон улсын харилцааны шинэ үе шат, Япон, БНХАУ, Өмнөд Солонгосын хөгжлийн улс төр, эдийн засгийн чиглэл, эдгээр нь АНУ-д ямар ач холбогдолтойг тодорхойлон хэтийн төлөвд нь үнэлэлт өгч, зоригтой таамаглал хийсэн юм.

Америкийн эрдэмтэн Зүүн-хойд Ази ирээдүйн америкийн стратеги, улс төр, эдийн засагт ямар ач холбогдолтойг онцлон тэмдэглээд, энэ бүс нутгийн ач холбогдлыг өндөржүүлэхийн тулд америкийн засаг захиргааны хэлэлцэх асуудалд шинээр оруулах хэрэгтэй юм гэжээ. Р. Скалапиногийн бичсэн зүйлийн оршилд Япон, БНХАУ, Өмнөд Солонгосын дотоод, гадаад бодлогын өөрчлөлтийн ерөнхий төрхийг дүрслэн үзүүлжээ. Дараа нь зохиогч америк-японы, америк-хятадын, америк-өмнөд солонгосын харилцаа, тэдгээрийн зөрчил, хэтийн төлөвийг тусгай гарчгийн доор дүгнэн бичсэн байна. Тухайлбал, америк-японы харилцааг судлахдаа зохиогч эдийн засаг, худалдааны